



# ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



**2018 он**

## Гарчиг

Товчилсон үгийн тайлбар

Нэгдүгээр бүлэг. Удирдлага, зохион байгуулалт

Хоёрдугаар бүлэг. Санхүүгийн тайлангийн аудитын талаар

Гуравдугаар бүлэг. Гүйцэтгэлийн аудитын талаар

Дөрөвдүгээр бүлэг. Нийцлийн аудитын талаар

Тавдугаар бүлэг. Аймгийн ИТХ-ын захиалга, өөрийн санаачлагаар хийсэн аудитын талаар

Зургаадугаар бүлэг. Аймгийн ИТХ-д үзүүлэх үйлчилгээний талаар

Долоодугаар бүлэг. Дотоод ажлын талаар

Наймдугаар бүлэг. Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэлийн талаар

Есдүгээр бүлэг. Дүгнэлт, санал

Хавсралт

**Товчилсон үгийн тайлбар**

СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТАБ	Төрийн аудитын байгууллага
САГ	Санхүүгийн аудитын газар
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
НАГ	Нийцлийн аудитын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СТАУС	Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ОНТЕЗ	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
НББ	Нягтлан бодох бүртгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ГХБХБС	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын салбар
ХХАА	Хүнс, хөдөө аж ахуй
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын салбар
ММНБИ	Монголын Мэргэшсэн нягтлан бодогчдын институт
ТМЗ	Татварын мэргэшсэн зөвлөх
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ББӨ	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг

**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2018.07.05

Чойр хот

**Нэгдүгээр бүлэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:**

Төрийн аудитын байгууллагаас 2018 онд дэвшүүлсэн **“Аудитын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх”** зорилтын хүрээнд Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар нь гол үйл ажиллагаагаа чиглүүлэн Төрийн аудитын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон Аудитын олон улсын стандартын хүрээнд үйл ажиллагаагаа явууллаа.

2018 онд дэвшүүлсэн зорилтын хүрээнд Тэргүүлэх аудиторын А/04 дүгээр тушаалаар аудитын болон ажил, үйлчилгээний төлөвлөгөөг баталж, нийт 6 бүлэг 14 зүйл, 72 ажлыг төлөвлөж, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчтой үр дүнгийн гэрээ байгуулан, үйл ажиллагааны төлөвлөгөө, гэрээний үүргийн биелэлтийг хангаж, эхний хагас жилд төлөвлөсөн ажлыг 100% хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчтой үр дүнгийн гэрээ байгуулснаар үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг ажиллагсдын үр дүнгийн гэрээнд тусгуулж, байгууллагын 6 ажилтантай үр дүнгийн гэрээ, 2 ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллалаа.

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар нь Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/69 дүгээр тушаалаар баталсан бүтэц, орон тооны дагуу үндсэн 7 орон тоотой үйл ажиллагаагаа явуулсан бөгөөд ҮАГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу гэрээт нягтлан бодогч-бичиг хэргийн ажилтныг шинээр томилж, нийт 8 орон тоотой ажиллалаа.

Хүний нөөцийн 5 буюу 62.5% нь аудитын үйл ажиллагааг, 3 буюу 37.5% нь удирдлага болон нийтлэг үйлчилгээний албаны ажил үүргийг гүйцэтгэж, дэвшүүлсэн зорилтыг хангаж ажиллалаа.

2018 оны 03 дугаар сард Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөнд оролцож, 2017 оны үйл ажиллагаагаа үнэлж дүгнүүлэн ажлын үр дүнгээр орон нутгийн төрийн аудитын байгууллагын хэмжээнд 3 дугаар байр эзэлж, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнууллаа.

2018 оны эхний хагас жилийн байдлаар сар тутам хүний нөөцийн хөдөлгөөний мэдээ болон ажлын явцын тайланг гарган ҮАГ-т цахимаар хүргүүлж, шаардлагатай асуудлыг тухай бүр шийдвэрлүүллээ.

Байгууллагын шуурхай хуралдааныг 7 хоног бүрийн Даваа гаригт явуулж, өмнөх 7 хоногт өгсөн үүрэг даалгаврын биелэлт, тухайн 7 хоногт хийх ажлыг хэлэлцэн нийт 16 хурлын тэмдэглэл хөтөлсөн байна.

Тайлант хугацаанд Төрийн аудитын байгууллагын үйлчилгээний ажилтны ажлын байрны тодорхойлолт, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журмыг тус тус шинэчлэн боловсруулж баталлаа.


Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны эхний хагас жилийн үндсэн үйл ажиллагаа, түүний үр дүнг тоон үзүүлэлтээр нэгтгэн харуулбал:

- ❖ 2018 оны эхний хагас жилийн байдлаар Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар нь санхүүгийн тайлангийн 82, гүйцэтгэлийн 3, нийцлийн 1, нийт 86 аудитыг хийж гүйцэтгэсэн бөгөөд дээрх аудитуудыг хийж гүйцэтгэхэд нийт 188/1579 хүн/өдөр зарцуулж, 2083 илүү цаг ажиллалаа.
- ❖ 2018 оны эхний хагас жилд хийж гүйцэтгэсэн аудитаар нийт 31,500.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, зөрчлийн 70.1% буюу 22,082.5 сая төгрөгийн алдаа, зөрчлийг аудитын явцад залруулан, 33.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд акт тогтоож, 189.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд албан шаардлага, зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх 177 зөвлөмж өгч ажиллалаа.
- ❖ Аудитаар нийт 33.8 сая төгрөгийн акт тогтоож, тайлант хугацаанд актын 78.1% буюу 26.4 сая төгрөгийг барагдуулж ажилласан, 21.9% буюу 7.4 сая төгрөг нь хугацаа болоогүй актын үлдэгдэл байна. Нийт тогтоосон актаас 26.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүллээ.
- ❖ Тайлант жилд 189.6 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгснөөс 128.0 сая төгрөгийн зөрчлийг арилгаж, албан шаардлагын хэрэгжилт 67.5%-тай байна.
- ❖ Тайлант хугацаанд 177 зөвлөмж өгсний 46.4%-ийг хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой, 26%-ийг бүртгэл, тайлагналтай холбоотой, 13%-ийг дотоод хяналтыг сайжруулах, 9.6%-ийг арвилан хэмнэх, үр ашиг, үр нөлөөг сайжруулахтай холбоотой, 5%-ийг бусад асуудлаар өгсөн зөвлөмж эзэлж байгаа ба нийт өгсөн зөвлөмжийн 53.7% буюу 95 зөвлөмжийг хэрэгжүүлж, 46.3% буюу 82 зөвлөмж аудит хийгдсэн хугацаанаас шалтгаалан хэрэгжих шатандаа буюу хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.
- ❖ 2018 оны эхний хагас жилд хийж гүйцэтгэсэн аудитаар 22,236.6 сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлж бүртгэснээр Төрийн аудитын газрын зардлын 1 төгрөгт ногдох хүлээн зөвшөөрөгдсөн үр өгөөж 298.5 төгрөг байна.
- ❖ Өмнөх оноос шилжиж ирсэн актын 129.4 сая төгрөгөөс 16% буюу 20.7 сая төгрөгийг барагдуулж, 595.7 сая төгрөгийн албан шаардлагаас 60.6% буюу 360.9 сая төгрөгийн албан шаардлагын хэрэгжилтийг хангаж, 119 зөвлөмжөөс 77 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.
- ❖ Зөрчил гаргасан 26 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлснээс 88.5% буюу 23 албан тушаалтанд хариуцлага тооцуулж, хугацаа болоогүй 1, хариу ирүүлээгүй 2 санал байна.

Тайлант хугацаанд Гүйцэтгэлийн аудит 3, Нийцлийн аудит 1, нийт 4 аудит хийж гүйцэтгэснээс 1 аудитыг УАГ-ын нэгдсэн удирдамжаар, 2 аудитыг аймгийн ИТХ-ын

захиалгаар, 1 аудитыг өөрийн санаачлагаар гүйцэтгэлээ. Гүйцэтгэсэн аудитыг диаграммаар харуулбал:

**2018 оны эхний хагас жилд гүйцэтгэсэн ГА болон НА**




Диаграммаас харахад: 2018 он эхний хагас жилд хийж гүйцэтгэсэн Гүйцэтгэлийн болон Нийцлийн аудитын 25%-ийг YAГ-ын нэгдсэн төлөвлөгөөгөөр, 50%-ийг АИТХ-ын захиалгаар, 25%-ийг өөрийн санаачлагаар хийж гүйцэтгэсэн байна.

2018 оны эхний хагас жилд хийж гүйцэтгэсэн аудитын тоон үзүүлэлтийн нэгтгэлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

Аудитын төрөл	Аудитын тоо	Илрүүлсэн алдаа, зөрчлийн дүн	Тогтоосон төлбөрийн актын дүн	Өгсөн албан шаардлагын дүн	Бүртгэсэн үр өгөөжийн дүн	/сая төгрөгөөр/	
						Үүнээс: Залруулсан дүн	Өгсөн зөвлөмж /тоо/
Санхүүгийн тайлангийн аудит	82	28,995.4	31.1	167.0	22,236.6	22,082.5	140
Гүйцэтгэлийн аудит	3	2,503.0	1.0	22.6	-	-	19
Нийцлийн аудит	1	1.7	1.7	-	-	-	18
<b>ДҮН</b>	<b>86</b>	<b>31,500.1</b>	<b>33.8</b>	<b>189.6</b>	<b>22,236.6</b>	<b>22,082.5</b>	<b>177</b>

2018 оны эхний хагас жилд хийж гүйцэтгэсэн аудитаар тогтоосон акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг графикаар харуулбал: /сая.төг, тоо/



2018 оны эхний хагас жилд хийж гүйцэтгэсэн аудитаар тогтоосон актын 78.1%-ийг барагдуулж, өгсөн албан шаардлагын 67.5% буюу 128.0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулан, зөвлөмжийн 53.7% буюу 95 зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажилласан ба аудит хийгдсэн хугацаанаас шалтгаалан актын 21.9%, албан шаардлагын 32.5%, зөвлөмжийн 46.3%-ийн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

**Хоёрдугаар бүлэг. Санхүүгийн тайлангийн аудитын талаар:**

Төрийн аудитын байгууллага хуулиар тодорхойлогдсон чиг үүргийнхээ хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1, 8.9.2, 8.9.3, 8.9.4, 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 18.2, 18.5 дахь заалтуудын дагуу улс, орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрууд, тусгай зориулалтын сангуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчдын, улс, орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчит хуулийн этгээд, тусгай зориулалтын сангийн нийт 82 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийсний 83%-ийг төрийн аудитын байгууллага, 17%-ийг хувийн хэвшлийн хараат бус аудитын компаниар гэрээгээр гүйцэтгүүлээ.

Тайлант хугацаанд санхүүгийн тайлангийн аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн 1, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 5, тусгай сан 18, төсвийн шууд захирагчийн 30, тусгай шилжүүлгийн 22, ОНӨААТҮГ-ын 6, нийт 82 байгууллагын санхүүгийн тайлан хамрагдав.

Санхүүгийн тайлангийн аудитаар 68 байгууллагад өгсөн санал дүгнэлтийн 57 буюу 83.8%-ийг зөрчилгүй, 8 буюу 11.8%-ийг хязгаарлалттай, 1 буюу 1.5%-ийг сөрөг санал дүгнэлт эзэлж, 2 буюу 2.9%-д дүгнэлт гаргахаас татгалзжээ.

“Санхүүгийн тайлангийн аудитад итгэл үзүүлэхэд баримтлах журам”-ын дагуу Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар 4 байгууллагад итгэл үзүүлж, 14 байгууллагыг түүвэрт хамруулсан бөгөөд аудитад хамрагдвал зохих санхүүгийн тайланг 100% хамруулсан байна.

Санхүүгийн аудитаар нийт 188/1579 хүн/өдөр зарцуулж, 2,083 илүү цаг ажилласан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 28,995.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, илрүүлсэн зөрчлийн 76.1% буюу 22,082.5 сая төгрөгийн алдаа, зөрчлийг аудитын явцад залруулж, 31.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд акт тогтоож, 167.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд албан шаардлага өгч, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 140 зөвлөмж өгч ажиллалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 31.1 сая төгрөгийн актын 84.8% буюу 26.4 сая төгрөгийг тайлант хугацаанд барагдуулж, 167.0 сая төгрөгийн албан шаардлагын 76.6%-ийг хэрэгжүүлж, орон нутгийн төсөвт 26.4 сая төгрөгийг төвлөрүүллээ.

Тайлант хугацаанд өгсөн 140 зөвлөмжийн 95 зөвлөмж буюу 67.9%-ийг хэрэгжүүлж, 45 зөвлөмж буюу 32.1% нь хэрэгжих шатандаа байна.

Өмнөх оноос шилжиж ирсэн СТА-ын 4.8 сая төгрөгийн актыг 100% барагдуулан, 116.2 сая төгрөгийн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж, 41 зөвлөмжийн үлдэгдлээс 65.9% буюу 27 зөвлөмжийн биелэлтийг хангуулсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 22,236.6 сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэн бүртгэснээр санхүүгийн тайлангийн аудитаар бий болсон Төрийн аудитын газрын зардлын 1 төгрөгт ногдох үр өгөөж 298.5 төгрөг болж байна.

Санхүүгийн тайлангийн аудитад АДБОУС, АОУС-ыг мөрдөж, УСНББОУС, СТОУС, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврыг шалгуур болгон ашиглаж, журам, гарын авлагын дагуу гүйцэтгэв. Аудитад СТАУС программыг ашиглаж, аудитын үе шат бүрд чанарын хяналтыг хэрэгжүүллээ.

Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсөв захирагч нарт албан ёсоор гардуулан өгч тус аудитын үр дүн, илрүүлсэн алдаа, зөрчлийн шалтгаан, үр дагавар, тэдгээрийг арилгах, өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар



танилцуулсан бөгөөд ҮАГ-ын Санхүүгийн аудитын газарт болон үйлчлүүлэгч байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан.

2018 оны эхний 5 сар 1 орон тоо дутуу ажилласнаас Санхүүгийн тайлангийн аудитыг 3 аудитор гүйцэтгэж, аудитын менежерийг СТА-д татан оролцуулж, аудитын чанарын хяналтыг Тэргүүлэх аудитор хэрэгжүүлэн ажилласан ба дунджаар 1 аудитор 16 аудитыг хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан хуваарийн дагуу хараат бус хөндлөнгийн аудитын “Саруул Баян-Уул Аудит” ХХК-тай сонгон шалгаруулалтын үндсэн дээр гэрээ байгуулж, 14 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийлгэлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг ангилан харуулбал:

➤ НББ, тайлагнал	23,921.2 сая
➤ Дотоод хяналт, хариуцлага	732.0 сая
➤ Төсвийн төлөвлөлт, зарцуулалт	239.7 сая
➤ Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт	1,550.5 сая
➤ Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөө	407.0 сая
➤ Улс, орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт	2,015.8 сая
➤ Бусад зөрчил болон худалдан авалт	129.2 сая



Жил бүрийн санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийг байгууллага тус бүрээр болон балансын дансдаар нэгтгэн мэдээллийн санг баяжуулж, байгууллага бүрээр нээсэн хувийн хэргийн өөрчлөлт, шинэчлэлтийг тухай бүр хийж ажиллалаа.


Санхүүгийн тайлангийн аудитаар 23.9 сая төгрөгийн ажил, үйлчилгээний төлбөр авахаар гэрээ байгуулан ажилласнаас 10.1 сая төгрөгийг төрийн аудитын байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд, 13.8 сая төгрөгийг гэрээт аудитын компанийн дансанд төвлөрүүллээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай болон сөрөг санал дүгнэлт авсан, дүгнэлт өгөхөөс татгалзсан 13 албан тушаалтанд хариуцлага тооцуулах тухай саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлснээс 11 албан тушаалтанд хариуцлага тооцуулж, 2 нь хариу ирүүлээгүй байна.


Санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, тогтоосон акт, өгсөн албан шаардлага, зөвлөмж, түүний биелэлтийг өмнөх онтой харьцуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Санхүүгийн тайлангийн аудитаар 2018 онд 28,995.4 сая төгрөгийн алдаа, зөрчлийг илрүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 286.2%-иар өссөн байна.

Илрүүлсэн алдаа, зөрчлийн дүн /сая.төг/




Залруулсан алдааны дүн




Санхүүгийн тайлангийн аудитын явцад залруулсан алдаа, зөрчлийг өмнөх онтой харьцуулахад 17,235.5 сая төгрөг буюу 4 дахин өссөн байна.


Тогтоосон акт, барагдуулалт /сая.төг/



Өгсөн албан шаардлага, түүний биелэлт/сая.төг/



Өгсөн зөвлөмж, түүний биелэлт/тоо/



2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон акт өмнөх оноос 181.0%-иар, өгсөн албан шаардлага 282.9%-иар, зөвлөмжийн тоо 12-оор тус тус буурсан байна.

**ОНТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

ОНТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд ТТЗ-ийн 3, төсвийн шууд захирагчийн 14, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага 20, тусгай сангийн 16, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 5, нийт 58 санхүүгийн тайлан, орон нутгийн нөөц хөрөнгө, автозамын сан, сум хөгжүүлэх сан, ахмадын байгууллагын санхүүгийн дэмжлэг, мал эмнэлгийн үйлчилгээ, ахмадын нэгдсэн сан, хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансдын зардлын гүйлгээг нэгтгэсэн байна.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын санхүүгийн тайлан, Засгийн газрын шугамаар авч, ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд хамааруулна” гэж заасны дагуу орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайланг 100% хамруулсан байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т “аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлэх..” гэж заасны дагуу ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Төрийн аудитын байгууллагад хугацаанд нь ирүүлсэн болно.

Орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт **26,981.0** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад **21,671.9** сая төгрөгийн материаллаг алдааг залруулж, **26.3** сая төгрөгийн зөрчилд 26 акт тогтоож, **168.5** сая төгрөгийн алдаа, зөрчилд 8 албан шаардлага хүргүүлж, алдаа, зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцуулах 8 санал хүргүүлж, **703.0** сая төгрөгийн алдааг залруулаагүй бөгөөд зөрчил, дутагдлыг арилгах **4,411.3** сая төгрөгийн 91 зөвлөмж өглөө.

Нийт зөрчил дутагдлын 31.6% буюу **8,538.6** сая төгрөг нь ТЕЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудтай холбоотой ба нэгтгэсэн тайланг аудитлах явцад 68.4% буюу **18,442.4** сая төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ.

ОНТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитад нийт 58 байгууллагын санхүүгийн тайланг хамруулснаас 2 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлэн, 14 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 34 байгууллагад “зөрчилгүй”, 3 байгууллагад “хязгаарлалттай”, 3 байгууллагад “сөрөг” санал дүгнэлт өгч, 2 байгууллагад “дүгнэлт өгөхөөс татгалзсан” байна. Нийт байгууллагын 13.7% буюу 8 байгууллагын санхүүгийн тайланд хязгаарлалттай, сөрөг, татгалзсан дүгнэлт өгсөн байна.

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өглөө.

Аудитын дүнд үндэслэн Төсвийн ерөнхийлөн захирагч буюу аймгийн Засаг даргад 4 зөвлөмж өгсөн байна.

**Аймгийн 2017 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит**

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн 2017 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

ТЕЗ-аас ирүүлсэн аймгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан 16,499.7 сая төгрөгийн орлого, 14,733.6 сая төгрөгийн зарлагын гүйцэтгэлийг баталгаажуулав.

Аудитаар төсвийн орлого, зарлагыг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүй, төсвийн зардлын хэмнэлтээс үүссэн эх үүсвэрийг дараагийн төсвийн жилд бусад зардалд шилжүүлэн санхүүжүүлж байгаа нь орон нутгийн төсвийн зардал нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлсэн, зарим албан тушаалтны буруугаас ажлаас халагдсан хүмүүст шүүхийн шийдвэрээр 56.8 сая төгрөгийг олгож төсвийг үргүй зарцуулсан зөрчлүүд илэрлээ.

Говьсүмбэр аймгийн 2017 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийж, аудитаар “Төсвийн тухай хуульд заасан нөхцөл, шаардлагыг баримтлахгүйгээр төвлөрсөн орлогын хэмжээтэй уялдуулан зарлагыг нэмэгдүүлж, төсөвт өөрчлөлт оруулсан байна” гэсэн дүгнэлт өгч, тайланг хуулийн хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүллээ.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн аймгийн ТЕЗ-д 5 зөвлөмж өгч ажиллалаа.

**Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайлангийн аудит**

Тайланг хугацаанд 5 төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, 3 ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “Зөрчилгүй”, 2 ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн болно. Үүнд: Эрүүл мэндийн салбарын болон Баянтал сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тус тус “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгөгдсөн байна.

Аудитаар нийт **2,101.1** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад **30.0** сая төгрөгийн материаллаг алдааг залруулж, хариуцлага тооцуулах 2 санал хүргүүлж материаллаг бус зөрчил, дутагдлыг арилгах **1,942.5** сая төгрөгийн 15 зөвлөмж өглөө.

**Төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудит**

Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан хуваарийн дагуу 2018 онд төсвийн шууд захирагчийн 52 байгууллагаас 4 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлэн, 48 төсвийн шууд захирагчийг хамруулан аудит хийсэн байна. Үүнд: улсын төсвийн байгууллагын 9, орон нутгийн төсвийн байгууллагын 10, Эрүүл мэндийн салбарын байгууллага 4, боловсролын салбарын 16, ГХБХБС-ын 1, ХХАА-н салбарын 1, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 1, БОАЖС-ын 3 байгууллагын санхүүгийн тайланд санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар 3 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, “Зөрчилгүй” 38, “Хязгаарлалттай” 5, “Сөрөг” 1 санал дүгнэлт өгч, 1 санхүүгийн тайланд “санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” болно.

Аудитаар нийт 3,595.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 2,122.7 сая төгрөгийн материаллаг алдааг залруулж, 28.5 сая төгрөгийн зөрчилд 34 акт тогтоож, 114.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд 13 албан шаардлага хүргүүлж, алдаа, зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцуулах 7 санал хүргүүлж,

материаллаг бус зөрчил, дутагдлыг арилгах 1,329.4 сая төгрөгийн 100 зөвлөмж өглөө.

### **Тусгай сангуудын санхүүгийн тайлангийн аудит**

Тайлант хугацаанд аудитад нийт 18 санг хамруулан аудит хийснээс 6 санд “зөрчилгүй”, 1 санд “хязгаарлалттай” дүгнэлт гаргаж, 11 санг түүвэрт хамрууллаа.

Аудитаар нийт 2,098.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 188.8 сая төгрөгийн материаллаг алдааг залруулж, 0.5 сая төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 17.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, алдаа, зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцуулах 1 санал хүргүүлж, материаллаг бус зөрчил, дутагдлыг арилгах 2,488.8 сая төгрөгийн 14 зөвлөмж өглөө.

### **Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн аудит**

Аудитад нийт 6 орон нутгийн өмчит хуулийн этгээд хамрагдахаас бүрэн хамрагдаж, 5 байгууллагад “Зөрчилгүй” санал дүгнэлт өгч, 1 байгууллагад санал дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

Аудитаар нийт 2,758.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 2,627.4 сая төгрөгийн материаллаг алдааг залруулж, 2.1 сая төгрөгийн зөрчилд 3 акт тогтоож, 112.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, материаллаг бус зөрчил, дутагдлыг арилгах 16.9 сая төгрөгийн 8 зөвлөмж өглөө.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь хуулийн хугацаанд санхүүгийн тайланг ирүүлээгүй, бараа ажил үйлчилгээг худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТХ болон холбогдох журмыг зөрчсөн, ББӨ-ийг үнэн зөв тооцоогүй, он дамжсан авлага, өглөгийг барагдуулж ажиллаагүй зэрэг нийтлэг алдаа, зөрчил гаргасан байна.

### ***Гуравдугаар бүлэг. Гүйцэтгэлийн аудитын талаар:***

2018 оны эхний хагас жилд давхардсан тоогоор 12 байгууллагыг хамруулан 3 гүйцэтгэлийн аудит хийж гүйцэтгэсэн бөгөөд аудитад нийт 9/94 хүн/өдөр зарцуулж, 200 илүү цаг ажиллалаа. Тайлант хугацаанд гүйцэтгэсэн нийт 3 аудитын 1 аудитыг ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар, 2 аудитыг аймгийн ИТХ-ын захиалгаар тус тус хийж гүйцэтгэлээ.

Тайлант хугацаанд хийж гүйцэтгэсэн Гүйцэтгэлийн аудитаар нийт 2,503.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 1.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд акт тогтоож, 22.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд албан шаардлага өгч, алдааг засах, дахин гаргахгүй байх 19 зөвлөмж өглөө.

Гүйцэтгэлийн аудитаар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг тооцох хугацаа болоогүй байна.

Гүйцэтгэлийн аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн ангиллыг харуулбал:

✚ Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой	1,211.9 сая
✚ НББ, тайлагналтай холбоотой	291.2 сая
✚ Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой	1,000.0 сая

Өмнөх оноос шилжиж ирсэн Гүйцэтгэлийн аудитын актын үлдэгдэл 96.8 сая төгрөгийн 2.1% буюу 2.0 сая төгрөгийг барагдуулж, 467.2 сая төгрөгийн албан шаардлагын 244.8 сая төгрөг буюу 52.4%, 53 зөвлөмжийн 66%-ийг хэрэгжүүлсэн байна.

Тайлант хугацаанд дараах аудитуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

**ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар:**



Улсын төсвийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг

Монгол Улсын Ерөнхий аудитор 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөө, Гүйцэтгэлийн аудитын газрын нэгдсэн удирдамжийн дагуу Төрийн Аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т Гүйцэтгэлийн аудит хийлээ.

Тус аймагт 2017 онд батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2,576.4 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээний эрх шилжиж ирсэн байна.

Эрх шилжүүлсэн 10 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 3 ажлыг НТШ, 4 ажлыг харьцуулалт, 3 ажлыг шууд гэрээ байгуулж гүйцэтгэсэн байна. Шивээговь сумын 3-р сургуулийн барилгын дээврийн засварын ажлын тендер шалгаруулалттай холбоотой гомдол гарсаныг Сангийн яам хүлээн авч хянан шийдвэрлэсэн байна.

Тайлант хугацаанд улсын төсвийн хөрөнгө оруулалтын 10 төсөл, арга хэмжээний гэрээний нийт дүнг 2,542.2 сая төгрөгөөр байгуулж, гүйцэтгэлээр 2,519.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Санхүүжилтийг 22.5 сая төгрөгөөр дутуу олгосон нь 1 ажил гэрээний хугацаанд хийгдээгүй, он дамжсантай холбоотой байна.

Мөн 2012 онд эхэлсэн дуусаагүй барилга буюу Сүмбэр сумын 1 дүгээр багийн 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг 2017-2018 онд барьж дуусгахад 656.7 сая төгрөгийн төсөв батлагдсан байна. Тус ажлын гүйцэтгэлд 2017 онд 482.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд ажлыг ондоо багтааж хэрэгжүүлээгүй байна. Энэ нь 2017 оны 10 дугаар сард төсвийн тодотголоор үлдэгдэл санхүүжилтийг баталж гэрээ байгуулсан, ажил гүйцэтгэх явцад хүйтний улирал эхэлсэнтэй холбоотойгоор ус дулааны байгууллагаас огтолгоо хийх боломжгүйг мэдэгдсэний дагуу 2018 оны 04 сард ажлаа үргэлжлүүлэхээр төлөвлөж, ажлыг эхлүүлэн 75%-ийн гүйцэтгэлтэй байна. Гэрээний хугацаанд сунгалт хийгдээгүй байна.

Аудитаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудыг төлөвлөхдөө тендерийн баримт бичигт ажлын тоо хэмжээг зөрүүтэй тусгасан, хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулсан ажлуудад хөрөнгө зарцуулсан, үнэлгээний хороо нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3-т заасныг баримталж ажиллаагүй, тендер ирүүлэх хугацааг 17 хоногоор тогтоосон, техникийн тодорхойлолтонд заасан ажлыг дутуу буюу чанаргүй гүйцэтгэсэн, ажил хүлээн авах комисс ажлуудыг чанаргүй буюу дутуу хийсэн байхад хүлээн авсан зөрчлүүд илэрсэн

бөгөөд тендер шалгаруулалттай холбоотой гомдол маргаан жил бүр гарсаар байгаа нь үнэлгээний хороо хууль журмыг баримтлан ажиллахгүй байгааг харуулж байна.

Аудитын явцад нийт 472.9 сая төгрөгийн зөрчил, дутагдал илрүүлж, зөрчил дутагдлыг арилгуулах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

**Аймгийн ИТХ-ын захиалгаар:**

Аймгийн “Ус-Ду” ОНӨААТҮГ-ын 2016-2017 оны үйл ажиллагааны үр дүн



Аудитад тус байгууллагын 2016-2017 оны үйл ажиллагааг хамрууллаа. Аудитаар үндсэн 4 зорилт дэвшүүлсэн бөгөөд дэвшүүлсэн зорилтын хүрээнд дараах дүгнэлтийг өгсөн байна. Үүнд:

- Байгууллага үндсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. Техник тоног төхөөрөмж, технологийн шинэчлэл хийгдээгүй улмаас үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар хангалтгүй байна. Байгууллагыг үүсгэн байгуулсан баримт бичиг болох компанийн дүрмийг шинэчлэн батлуулах, үйлдвэрлэлийн төлөвлөгөө гаргаж ажиллах, хэрэглэгчидтэй гэрээ байгуулан, дүгнэх, байгууллагын үйл ажиллагааны талаар орон нутгаас баримтлах бодлогын баримт бичиг боловсруулж ажиллах шаардлагатай байна. Техник технологийн шинэчлэл хийн, боловсон хүчин, хүний нөөцийн бодлого хэрэгжүүлж, үнэ тарифыг зохистой хэмжээнд нэмэгдүүлэн, санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлснээр байгууллага үр ашигтай ажиллах боломжтой байна.
- Үйл ажиллагааны орлого, зардлыг бодитой төлөвлөөгүй, үнэн зөв бүртгэж тайлагнаагүй, мөнгөн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт сул, үнэ, тарифыг бүтээгдэхүүний өртөг, хэрэглэгчдийн төлбөрийн чадварт үндэслэн зохистой хэмжээнд тогтоох, өртгийг үнэн зөв тооцож, тайлагнах шаардлагатай байна
- Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулаагүй, хөрөнгийн дансны ангиллыг буруу бүртгэж тайлагнасан байна.
- Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллаагүй, хяналтын тогтолцоог сайжруулах шаардлагатай байна

Гүйцэтгэлийн аудитаар нийт 2,030,192.0 мянган төгрөгийн зөрчил, дутагдал илрүүлснээс 985.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 22,290.7 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 2,006,576.0 мянган төгрөгийн зөрчил дутагдлыг арилгуулах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитын дүнг үндэслэн аймгийн ИТХ-ын дарга 1, Засаг дарга 3 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлж ажиллалаа.

Говьсүмбэр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2016-2017 оны үйл ажиллагааны үр дүн

Аудитад тус байгууллагын 2016, 2017 оны үйл ажиллагааг хамруулсан бөгөөд аудитаар нийт 123,528.7 мянган төгрөгийн зөрчлийг илрүүллээ.

Тус аудитаар үндсэн үйл ажиллагааны орлогыг нэр төрлөөр нь бодит тооцоо судалгаа, өмнөх оны гүйцэтгэл зэргийг харгалзан үнэн зөв төлөвлөж, батлуулаагүй, нягтлан бодогч цалинг буруу тогтоосноос үүссэн 2016 оны цалинг 344.9 мянган төгрөгөөр дутуу олгосон, 42 нэр төрлийн 150,087.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа, 54,853.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг ангиллын дагуу бүртгээгүй, НБББББ-т тусгагдсан хөрөнгийн ашиглалтын хугацааг баримтлаж ажиллаагүй, хувийн компанид түрээсийн гэрээгээр олгосон ноос пресслэгчийн зориулалтыг өөрчилсөн байхад хяналт тавьж ажиллаагүй, сумдын мал эмнэлгийн үржлийн тасгууд нь бараа материалын тайланг гаргаагүй зэрэг зөрчил дутагдлууд илэрсэн байна.



Гүйцэтгэлийн аудитын явцад тухайн аудиттай холбоотой байгууллагуудын удирдлага, санхүүгийн болон холбогдох ажилтнуудыг байлцуулан аудитын явцад тус байгууллагуудын хоорондын харилцаа, ажлын уялдаа, холбооноос шалтгаалан гарч буй зарим алдаа зөрчил, түүний үр дагавар, уг алдааг засаж, залруулах талаар уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, санал солилцож ажилласан нь тухайн ажил хариуцсан байгууллага, ажилтан нар өөр өөрсдийн хүлээсэн эрх үүрэг болон хийж гүйцэтгэх ажил, тухайн байгууллагуудын ажлын уялдаа холбоог ойлгуулсан үр өгөөжтэй ажил боллоо.

Аудитын дүнг шалгагдагч байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтан бусад холбогдох албан тушаалтанд танилцуулан, аудитын тайланг тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан ҮАГ болон шалгагдагч байгууллага, холбогдох албан тушаалтанд хүргүүлэн ажиллалаа.



Гүйцэтгэлийн аудитын явцад ГАГ-аас ирүүлсэн судалгаа, мэдээллийг бүрэн гаргаж, мөн аудитын тайлан болон бусад холбогдох материалыг цахимаар болон цаасаар цаг хугацаанд нь хүргүүлж, ҮАГ-аас зохион байгуулсан цахим хурал, сургалтанд бүрэн хамрагдлаа.

**Дөрөвдүгээр бүлэг. Нийцлийн аудитын талаар:**

2018 оны эхний хагас жилд давхардсан тоогоор 72 байгууллагыг хамруулан өөрийн санаачлагаар 1 Нийцлийн аудитыг хийж гүйцэтгэн, аудитад нийт 3/32 хүн/өдөр зарцуулж, 64 илүү цаг ажиллалаа.

**Өөрийн санаачлагаар:**



Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа, тамхи худалдах, түүгээр үйлчлэх хууль, журмын хэрэгжилт

Аймгийн хэмжээнд 2017 оны жилийн эцсийн байдлаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 44, тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрөлтэй 24 иргэн, аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна. Тусгай зөвшөөрөл эзэмшиж буй хуулийн этгээдийн үйл ажиллагааны төрлийг авч үзвэл хүнсний дэлгүүр 54, зоогийн газар 9, ресторан 1, баар 2, кафе 2 байна.

Тусгай зөвшөөрлийн 39.7% нь хуулийн хүрээнд олгогдоогүй байна. 2016-2017 онд нийт 9 байгууллагын тусгай зөвшөөрлийг шинээр олгох, сунгах үйл явц хуулийн хугацаанд хийгдээгүй, тэмдэгтийн хураамжийг бүрэн төвлөрүүлээгүй иргэн, ААНБ-д тусгай зөвшөөрөл олгожээ. Согтууруулах ундаа, тамхи худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох болон сунгахдаа хуульд заасан хугацааг баримтлаагүй, шийдвэрлэх хугацааг хэтрүүлсэн байна.

Иргэн, ААНБ-д ногдуулсан согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжид 2016 онд 9.3 сая, 2017 онд 12.4 сая төгрөгийг аймгийн тэмдэгтийн хураамжийн дансанд төвлөрүүлэхээр, 2015-2017 онд тамхи худалдах тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжинд 6.8 сая төгрөгийг сумдын орон нутгийн дансанд төвлөрүүлэхээр тус тус ногдуулсан боловч 1.7 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

Хяналт шалгалт хангалтгүйгээс үйл ажиллагаа явуулаагүй болон зөрчил гаргасан зарим иргэн, ААНБ-ын тусгай зөвшөөрлийг цуцлаагүй байна. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой иргэд, ААНБ-аас ирүүлсэн өргөдөл, гомдлыг бүрэн бүртгээгүй, хуулийн хугацаанд шийдвэрлээгүй байна.

Тайлант хугацаанд гүйцэтгэсэн Нийцлийн аудитаар нийт 1.7 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлсэн бөгөөд 1.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд акт тогтоож, зөрчлийг арилгуулах 1 албан шаардлага өгч, алдааг засах, дахин гаргахгүй байх 18 зөвлөмж өгч ажиллалаа.

Нийцлийн аудитаар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг тооцох хугацаа болоогүй байна. Нийцлийн аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой байна.



Аудитын дүнг шалгагдагч байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтан бусад холбогдох албан тушаалтанд танилцуулан, аудитын тайланг тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан шалгагдагч байгууллага болон холбогдох албан тушаалтанд хүргүүлэн ажиллалаа.


Өмнөх оноос шилжиж ирсэн Нийцлийн аудитын 27.7 сая төгрөгийн актын 17.9 сая төгрөг буюу 64.6 хувийг барагдуулж, 12.4 төгрөгийн албан шаардлагын үлдэгдэлтэй, 25 зөвлөмжөөс 15 буюу 60%-ийг хэрэгжүүлсэн байна.

**Тавдугаар бүлэг. Аймгийн ИТХ-ын захиалга, өөрийн санаачлагаар хийсэн аудитын талаар:**

2018 оны эхний хагас жилд аймгийн ИТХ-ын захиалгаар аймгийн “Ус-Ду” ОНӨААТҮГ, Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагааны үр дүнд нийт 2 Гүйцэтгэлийн аудитыг тус тус хийж гүйцэтгэлээ. Уг аудитуудад нийт 5/66 хүн/өдөр 200 илүү цаг ажиллалаа.

Аудитаар нийт 2,030.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлсний 1.0 сая төгрөгийн алдаа зөрчилд акт тогтоож, 15.5 сая төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага өгч, алдаа зөрчлийг арилгах, дахин гаргахгүй байх тухай 15 зөвлөмж өглөө. Аудитаар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг тооцох хугацаа болоогүй байна.

**Илрүүлсэн алдаа, зөрчил**



Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 59.7% нь арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой, 26% нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой, 14.3% нь НББ, тайлагналтай холбоотой зөрчил дутагдлууд байна.

2018 оны эхний хагас жилд өөрийн санаачлагаар 1 Нийцлийн аудитыг хийж гүйцэтгэсэн бөгөөд аудитад нийт 3/32 хүн/өдөр 64 илүү цаг ажиллалаа.

Аудитаар нийт 1.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлсний 1.7 сая төгрөгийн алдаа зөрчилд акт тогтоож, алдаа зөрчлийг арилгуулах 1 албан шаардлага өгч, алдаа зөрчлийг арилгах, дахин гаргахгүй байх тухай 18 зөвлөмж өглөө. Аудитаар илрүүлсэн алдаа зөрчил нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой байна.

Аудит хийгдсэн хугацаанаас шалтгаалан аудитаар тогтоосон акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

Аудитын дүнг шалгагдагч байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтан бусад холбогдох албан тушаалтанд танилцуулан, аудитын тайланг тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан шалгагдагч байгууллага болон холбогдох албан тушаалтанд хүргүүлэн ажиллалаа.

**Зургаадугаар бүлэг. Аймгийн ИТХ-д үзүүлэх үйлчилгээний талаар:**

Төрийн аудитын газраас “Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланд аудит хийж, дүгнэлт гарган аудитын тайлан дүгнэлтийг аймгийн ИТХ-д хүргүүлэн тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлээ.





2018 оны аудитын төлөвлөгөөнд аймгийн ИТХ-ын захиалгаар 2 гүйцэтгэлийн аудитыг хийж гүйцэтгэхээр баталсан бөгөөд төлөвлөгөөний дагуу аудитыг цаг хугацаанд нь гүйцэтгэж, аудитын тайланг аймгийн ИТХ-д тухай бүр хүргүүлэн ажиллалаа.

**Долоодугаар бүлэг. Дотоод ажлын талаар:**


**Хүний нөөцийн бодлого:** Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар нь 2018 оны эхний хагас жилд батлагдсан орон тоо 7, гэрээт ажилтан-1, нийт 8 орон тоогоор бүрэн ажилласан. Үүнд: дарга, тэргүүлэх аудитор 1, аудитын менежер 1, ахлах аудитор 1, аудитор 3, жолооч 1, гэрээт нягтлан бодогч-1 байна.

Тус аймаг дахь Төрийн аудитын газрын хүний нөөцийн статистик тоо мэдээг дараах байдлаар харуулбал:

Нийт 8 хүн ажиллаж байгаагаас 3 буюу 37.5% эрэгтэй, 5 буюу 62.5% эмэгтэй ажилтан байна. Насны бүтцийг авч үзвэл 62.5% нь 35 хүртэлх, 25% нь 35-40, 12.5% нь 40-өөс дээш насных байна.



Нийт ажиллагсдын 37.5% нь магистер, 50 % нь бакалавр, 12.5% бүрэн дунд боловсролтой бол, 37 % нь 10-15 жил, 25 % нь 5-10 жил, 25 % нь 0-5 жил, 13 % нь 15-аас дээш жил төрийн байгууллагад тогтвор суурьшилтай ажилласан байна.




Нийт ажилчдын 7 нь нягтлан бодогч мэргэжилтэй бол тэдний 4 нь мэргэшсэн нягтлан бодогч, 3 нь Татварын мэргэшсэн зөвлөх, 1 нь хос мэргэжилтэй байна.

Тайлант хугацаанд шинээр нэг аудитор, гэрээт нягтлан бодогч тус тус томилогдон ажиллалаа. Шинээр томилогдсон ажилтнуудад ажлыг хүлээлгэн өгөх комиссыг тэргүүлэх аудиторын тушаалаар тухай бүр томилж, ажлыг хүлээлцүүлээ.

Төрийн аудитын байгууллагын сонгон шалгаруулалт болон төрийн албаны мэргэшлийн шалгалтад тус тус тэнцэн, туршилтын хугацаагаар ажиллаж байсан аудитор Б.Дарханбат, М.Ундармаа нарыг Төрийн аудитын байгууллагын ажилтны тангараг өргүүлэх ёслолын ажиллагааг зохион байгууллаа.

Тангараг өргөх ёслолын ажиллагаанд аймгийн ИТХ-ын дарга Г.Батзам, аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга Б.Содном нарыг урьж оролцууллаа.



Төрийн аудитын байгууллагын ажилтан албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг Авлигын эсрэг хуулийн дагуу хугацаанд нь хүлээн авч, мэдээ тайланг УАГ-т хүргүүлэн, Авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллалаа. Төрийн болон албаны нууцтай холбоотойгоор

ажилтнуудын хувийн дугаар бүхий лацыг тогтмол ашиглаж хэвшсэн байна.

Ажилтнуудын хувийн хэргийн бүрдэл болон хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан судалгаануудыг шинэчлэн гаргалаа.

Ажилтнуудтай 2018 онд бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ нийлүүлэх үр дүнгийн гэрээ байгуулж, үйлчилгээний 2 ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулж, Байгууллагын дотоод журам, ажиллагсадтай байгуулсан үр дүнгийн гэрээний дагуу

ажиллагсдын 2018 оны эхний хагас жилийн үр дүнгийн гэрээний биелэлт, ажлын үр дүнг үнэлж, дүгнэлээ.

Тайланд хугацаанд ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчил гаргасан ажилтан байхгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллалаа. Байгууллагын дотоод журам, Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм, ажлын байрны тодорхойлолтыг бүх ажилтнуудад танилцуулан гарын үсэг зуруулж баталгаажуулан ҮАГ-ын ажлын албанд хүргүүлээ.

**Шагнал урамшуулал:** 2018 оны 3 дугаар сард ахлах аудитор Ц.Батсайханыг Үндэсний аудитын газрын “Төрийн хяналтын тэргүүний ажилтан” цол тэмдэгээр шагнууллаа. Байгууллагын 4 өндөр настанг сар шинийн баяраар хүлээн авч, хүндэтгэл үзүүлсэн бөгөөд 2 өндөр настанд ар гэрийн гачигдлыг харгалзан тэтгэмж олгож, нийт 680.0 мянган төгрөгийг зарцууллаа.

**Сургалт, зөвлөгөөн:** Төрийн аудитын байгууллагын мэргэжлийн тасралтгүй сургалтын хөтөлбөр, байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөө, бусад байгууллагаас зохион байгуулсан 16 удаагийн сургалтанд давхардсан тоогоор нийт 62 хүнийг хамрууллаа. Үүнд:

ҮАГ-аас зохион байгуулсан сургалтын хүрээнд:

- 2018 оны 03 дугаар сар-Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөнд дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа оролцлоо.
- 2018 оны 03 дугаар сар-Аудитын менежер Г.Наранбаяр, аудитор Б.Дарханбат нар “ТАБ-ын сургалт хөгжлийн стратегийн бодлогын баримт бичиг” сэдэвт сургалтанд
- 2018 оны 06 дугаар сар-Аудитор Б.Дарханбат, М.Ундармаа, Б.Анхтуяа нар шинэ ажилтны сургалтанд
- 2018 оны 06 дугаар сар-Аудитын менежер Г.Наранбаяр “Аудитыг хянан удирдах арга зүй” сэдэвт аудитын менежерүүдийн сургалтанд

Байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөний хүрээнд:

- 02 дугаар сар-Санхүүгийн тайлангийн аудитыг хийж гүйцэтгэх болон аудитын тайлан бичихэд анхаарах асуудал
- 04 дүгээр сар-СТАУС программыг ашиглах, Компьютерийн хэрэглээний программуудыг ашиглах, интернэт орчинд ажиллах, ТАБ-ын хэмжээнд мөрдөгдөж буй шинэчлэгдсэн болон шинээр батлагдсан журмуудын талаар
- 05 дугаар сар-Гүйцэтгэлийн аудитын журам, түүнийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх нь, Гүйцэтгэл, нийцлийн аудитын тайлан бичихэд анхаарах асуудал, Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлан болон статистик мэдээг боловсруулж тайлагнах журам, ҮАГ-ын цахим тестийн сан дахь тестийг ажиллах
- 06 дугаар сар- Аудитын үр өгөөжийг төлөвлөх, бүртгэх, тайлагнах, хянах, мэдээлэх журам, Төрийн болон албаны нууцын тухай хууль, холбогдох журмын тухай, 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн

зөрчлийг нэгтгэн дүгнэж дүн шинжилгээ хийх, цаашид анхаарах асуудлын талаар

Бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтын хүрээнд:

- 03 дугаар сар-Төрийн албаны төв зөвлөлөөс орон нутагт зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн нэгдсэн сургалт”-нд хамт олноороо,
- 05 дугаар сар-Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн ТМЗ-ийн эрх сунгах сургалтанд аудитын менежер Г.Наранбаяр, ММНБИ-ийн мэргэжлийн тасралтгүй хөтөлбөрийн сургалтанд дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа, Сангийн яамнаас зохион байгуулсан “Худалдан авах ажиллагааны аудит” сэдэвт сургалтанд ахлах аудитор Ц.Батсайхан, аудитор Б.Дарханбат,
- 06 дугаар сар-Сангийн яамнаас зохион байгуулсан “Орон нутгийн төсвийн удирдлагыг сайжруулах нь” сэдэвт сургалтанд аудитор Б.Дарханбатыг тус тус хамрууллаа.

2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу дотоод сургалтын төлөвлөгөөг ерөнхий мэдлэгийн болон мэргэжлийн чиглэлээр 14 төрлийн сэдвээр боловсруулан баталж, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу аудиторуудад 7 удаагийн 21 цагийн сургалтыг зохион байгууллаа.

2018 оны 01 дүгээр сард төсвийн захирагч нарт Санхүүгийн тайлангийн аудит эхлэхтэй холбоотойгоор 2017 оны санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад анхаарах асуудал, тайланг хуулийн хугацаанд ирүүлэх талаарх сургалтыг зохион байгуулж ажиллалаа.



#### **Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл түгээх үйл ажиллагаа:**

2018 оны эхний хагас жилийн байдлаар Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 98 мэдээллийг бэлтгэж, цахим хуудсанд байршуулж, байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд ил тод мэдээлж ажиллалаа. Ил тод мэдээллэсэн мэдээллийн 30 нь цаг үеийн шинжтэй мэдээлэл, 68 нь аудитын тайлан байна.

Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 77 зар болон мэдээллийг дотоод сүлжээгээр дамжуулан авч, ажиллагсдад тухай бүр танилцуулан мэдээ, мэдээллээр хангаж, шинээр батлагдсан журам зааврыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгууллагын 2017 оны үйл ажиллагааны тайланг хэвлүүлж, аймгийн ИТХ болон Засаг даргад хүргүүллээ. Байгууллагын мэдээ, мэдээлэл, үйл ажиллагааны ил

тод байдлыг хангаж ажиллах зорилгоор 2018 оны аудитын төлөвлөгөө, хөтөлбөр болон аудитын тайлан, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг байгууллагын ил тод байдлын самбар, цахим хуудсанд тухай бүр байршуулж ажиллалаа.

Байгууллагын ил тод байдлын самбарт хүний нөөцийн мэдээллийг шинэчлэн байршуулж, хийгдэж буй аудитын талаар тухай бүр, санхүү, төсвийн мэдээллийг сар бүр цаасан хэлбэрээр мэдээлж байна.

Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор аймгийн ИТХ-ын даргад 3 удаа, аймгийн Засаг даргад 3 удаа шаардлагатай аудитын тайлангуудыг тухай бүр хүргүүлэн ажиллалаа.

Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын 65 гүйцэтгэлийн аудитын 2, нийцлийн аудитын 1, нийт 68 аудитын тайланг байгууллагын цахим хуудсанд байршуулж, аудитын тайланг олон нийтэд ил тод мэдээллээ.

2018 оны СТА хийгдэж дууссантай холбоотой санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил дутагдал, цаашид анхаарах асуудлын талаар төсвийн захирагч нарт мэдээлэл хийлээ.

Тайлант хугацаанд САГ, ГАГ-аас зохион байгуулсан 2 удаагийн онлайн хуралд бүрэн бүрэлдэхүүнээр хамрагдан шаардлагатай мэдээ, мэдээллийг хүлээн авч, аудитын явц, үр дүн болон тулгамдсан зарим асуудлуудын талаар тухай бүр санал солилцож, орон нутгийн шаардлагатай мэдээ мэдээлэл, судалгаа, тайланг цахимаар болон цаасаар баталгаажуулан хүргүүлсэн.

2018 оны эхний хагас жилийн байдлаар ҮАГ-т нийт 52 удаагийн мэдээ, санал, судалгааг хүргүүлэн ажилласан байна. Үүнээс Тамгын газарт 19, Ажлын албанд 20, Стратеги удирдлагын газарт 6, САГ-т 3, ГАГ-т 1, НАГ-т 3 удаа тус тус холбогдох мэдээ, судалгаа, саналыг хүргүүлсэн байна.

**Өргөдөл, гомдол:** 2018 оны эхний хагас жилийн байдлаар төрийн аудитын байгууллагад ирүүлсэн өргөдөл, санал хүсэлтийг бүртгэж, хуульд заасан хугацаанд шийдвэрлэлтийг ханган ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллага болон иргэдээс төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаа болон хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн өргөдөл, санал, хүсэлт байхгүй бөгөөд бусад чиглэлээр 2 өргөдөл ирүүлснийг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан.

**Архив, албан хэрэг хөтлөлт:** 2018 оны эхний хагас жилийн байдлаар “А” тушаал 13, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой “Б” тушаал 4, нийт 17 тушаалыг хууль эрх зүйд нийцүүлэн гаргаж, тайлант хугацаанд ирсэн 296 бичигний 16.2% нь хариутай бичиг бөгөөд хариуг хугацаанд нь шийдвэрлэн холбогдох байгууллагуудад нь тухай бүр хүргүүлж, ҮАГ болон бусад байгууллагуудад 137 бичиг, албан тоотыг хүргүүлж, ирсэн, явсан бичгийн бүртгэл хөтлөлт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.

Албан хэрэг хөтлөлтийн ажлыг аудитын менежер Г.Наранбаяр хавсран гүйцэтгэж байсныг ҮАГ-ын Ажлын албанаас ирүүлсэн чиглэлийн дагуу гэрээт нягтлан бодогч С.Батцэцэгт шилжүүлэн өглөө.

Төрийн албан хэрэг хөтлөлтийн зааврын дагуу байгууллагад хөтлөгдөх 26 нэр төрлийн архивын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гаргаж баталгаажууллаа.

Мөн аймгийн Архивын тасагт төрийн аудитын байгууллагад хадгалагдаж буй байнга хадгалах 385, түр хадгалах 185, нийт 570 ш архивын нэгжийн жагсаалтыг гаргаж хүргүүллээ.

Тайлант хугацаанд шинээр томилогдсон ажилтнуудын хувийн хэргийн иж бүрдлийг хангаж, хувийн хэргийн баяжилт болон шинэчлэлтийг тухай бүр хийж, материалыг ангилан бүрдүүллээ.

2018 оны эхний хагас жилд хийгдсэн аудитын болон бусад баримт материалыг холбогдох ажилтнууд тухай бүр архивын нэгж болгон үдэж цэгцлэн, байгууллагын архив хариуцсан ажилтанд хүлээлгэн өгч ажиллалаа.

***Наймдугаар бүлэг. Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэлийн талаар:***

2018 оны эхний хагас жилд нийт 77.4 сая төгрөгийн урсгал үйл ажиллагааны төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 74.5 сая төгрөгийг зарцуулж, өр, авлагагүй ажиллалаа.

Тайлант хугацаанд анх батлагдсан төсвийн хуваарьт 2 удаа өөрчлөлт орж, өөрчлөлтийг тухай бүр мөрдөн ажиллаж ирлээ. Төсөв нийт дүнгээрээ анх батлагдсанаас 9.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь гэрээт нягтлан бодогч ажиллуулах болон цалингийн нэмэгдлүүдэд өөрчлөлт орсонтой холбоотойгоор цалин хөлс, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлууд нэмэгдсэн байна.

Нийт урсгал зардлын 61.7 сая төгрөг буюу 82.8%-ийг цалин, НДШ-ийн зардалд, 12.8 сая төгрөг буюу 17.2%-ийг бараа үйлчилгээний болон бусад зардалд зарцууллаа.

Төсвийн зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулж, зардлын зүйл ангиудыг тухай бүр хянан ажилласнаар зардлын бүлэг дотор гүйлгэн зарцуулаагүй болно.

Санхүүгийн тайлангийн аудитыг хувийн аудитын компаниар гүйцэтгүүлэхтэй холбоотойгоор батлагдсан журмын дагуу гэрээт аудитын компаниар аудит хийлгэсэн аудитын үйлчилгээний төлбөрийг гэрээний дагуу хянаж олгох зорилгоор Нэмэлт санхүүжилтийн дансаар 16.6 сая төгрөгийг төвлөрүүлж, 13.8 сая төгрөгийг аудитын компанид ажлын гүйцэтгэлээр олгосон бөгөөд эхний хагас жилийн байдлаар 2.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь өмнөх онд улсын төсөвт төвлөрүүлсэн үйлчилгээний хөлсийг Сангийн яамнаас одоог болтол эргүүлэн олгоогүйгээс өглөг, авлага үүссэн, мөн ХАК-ийн ажлыг дүгнэсний дараа үлдэгдэл төлбөрийг олгохтой холбоотой нэмэлт санхүүжилтийн дансанд үлдэгдэлтэй тайлагналаа.

Төсвийн тухай хуульд заасны дагуу байгууллагын санхүүгийн тайланг улирал болон хагас жилээр, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр гаргаж, ҮАГ-ын орон нутгийн ажлын албанд хүргүүлэн ажиллалаа.

2019 оны төсвийн төслийг боловсруулан холбогдох тайлбарын хамт 2018 оны 03 дугаар сард, байгууллагын хөрөнгийн судалгаа болон бусад санхүү, төсөвтэй холбоотой мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж, ҮАГ-т хүргүүлж ажиллалаа

2018 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг бэлтгэн гаргахтай холбоотой Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу байгууллагын эд хөрөнгийн тооллогыг тооллого хийх бүрэлдэхүүнийг тэргүүлэх аудиторын 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/13 тоот тушаалаар томилж баталгаажуулан, хөрөнгийн тооллогыг хийж, тооллогын үр дүнгээр 44.1 сая төгрөгийн актлах хөрөнгийн жагсаалтыг гарган тооллогын баримт материалын хамт ҮАГ-ын орон нутгийн Ажлын албанд хүргүүллээ.

Тооллогын үр дүнгээр албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийг шинэчлэн хөтөлж, гарын үсгээр баталгаажууллаа.

Тайлант хугацаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 57 дугаар тогтоолоор 3.7 сая төгрөгийн онлайн хурлын тоног төхөөрөмж, 2018.05.18-ний өдрийн А-4/1612 тоот албан бичгийг үндэслэн 107.7 сая төгрөгийн тээврийн хэрэгслийг данснаас дансанд шилжүүлэн авч, данс бүртгэлд тусгалаа.

Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөл эхний хагас жилд 1 удаа хуралдаж, ажлын тайлангаа гаргаж ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, 2018 оны эхний хагас жилд оруулбал зохих 76 мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн байршуулж, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, ажил гүйлгээг ҮАГ-ын шилэн дансны нэгдсэн цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбар, ил тод байдлын самбаруудад тогтмол байршуулж ажиллалаа.

### **Есдүгээр бүлэг. Дүгнэлт, ҮАГ-т уламжлах саналын талаар:**

**Дүгнэлт:** 2018 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээг 100% хэрэгжүүлэн ажиллалаа. 2018 оны эхний хагас жилд 1 орон тоо дутуу ажиллаж байсныг 04 дүгээр сард шийдвэрлүүлж, батлагдсан орон тоогоор бүрэн ажилласнаар аудиторуудын ажлын ачааллыг жигд хуваарилж, ҮАГ-ын дэмжлэгээр байгууллагын албан хэрэгцээнд ашиглагдаж буй суудлын автомашиныг шинэчлэн ажиллах нөхцөл, техникийн аюулгүй байдлыг ханган ажиллалаа.

#### **ҮАГ-т уламжлах санал, хүсэлт:**

- Санхүүгийн тайлангийн аудитад ашиглагдаж буй СТАУС програм нь өнөөгийн нөхцөл байдалд зөвхөн цахим архив үүсгэх хэлбэрээр ашиглагдаж байгаа нь аудит хийхэд цаг хугацаа их шаардагдаж хүндрэл үүсгэж байгаа тул уг программыг сайжруулах
- Ажиллагсдын ажиллах орчин, нийгмийн баталгааг хангаж ажиллахад төсөв хөрөнгө хүрэлцээгүйгээс шаардлагатай техник хэрэгслээр хангаж чадахгүй байгаа, одоогоор үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь хуучирч муудсан, ашиглалтын хугацаа дууссан, техникийн хоцрогдолд орсон зэргээс шалтгаалж зайлшгүй техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх асуудал тулгараад байна. Иймд байгууллагын албан ажлын хэрэгцээнд ашиглагдаж буй компьютер, техник хэрэгслийн ашиглалтын хугацаа дууссан, шинэчлэх шаардлагатай байгаа тул 2018 онд хийсэн Санхүүгийн тайлангийн аудитаар үйлчлүүлэгч байгууллагуудаас Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6 дахь хэсэгт заасны дагуу



аудитын үйлчилгээний төлбөр авсан тул уг төлбөрийг компьютер, техник хэрэгсэл худалдан авахад зарцуулах талаар шийдвэрлэж өгөх

- Боловсон хүчний мэдлэг, мэргэжлийн түвшинг дээшлүүлэх, ажлын туршлага эзэмшүүлэх, олон жил тогтвор суурьшилтай ажиллаж байгаа орон нутаг дахь Төрийн аудитын газрын ажилтнуудыг ҮАГ-аас зохион байгуулж буй гадаад сургалтанд хамруулах
- Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар төрийн аудитын байгууллагын дотоод журамд тусгасан хэдий ч нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх хэмжээний төсөв, хөрөнгө батлагддаггүйгээс орон нутаг дахь төрийн аудитын газрын ажилтнуудын нийгмийн асуудал орхигдож байгаа тул орон нутаг дахь төрийн аудитын байгууллагад тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй, тасралтгүй ажиллаж байгаа ажилтнуудыг орон сууцны дэмжлэг болон бусад дэмжлэгт шат дараалалтай хамруулах
- Орон нутаг дахь Төрийн аудитын байгууллагын ажилтнуудыг улсын эмнэлэгт нарийн мэргэжлийн үзлэг, оношлогоонд хамруулах нөхцөл боломжийг бүрдүүлэх талаар бодлогын хэмжээнд шийдвэрлэх

## ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР